



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 160

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.4.5, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай нийслэлийн Засаг даргын 2015 оны А/198 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3, 3.2.3, 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын аялал жуулчлалын зах зээлийн өнөөгийн байдал, жуулчдын онцлог” сэдэвт судалгааны ажлыг бага үнийн санал ирүүлсэн “Морьт Халиун” ХХК-иар гүйцэтгүүлсүгэй.
2. Гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн М.Болортуяад үүрэг болгосугай.
3. Судалгааны ажлын зардал болох 4.500.000 /дөрвөн сая таван зуун/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА

